**ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК**
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

**TRADE AND DEVELOPMENT BANK OF MONGOLIA**
**REPRESENTATIVE GOVERNING BOARD RESOLUTION**

2023 оны 12 сарын 06 өдөр | Дугаар 68 | Улаанбаатар хот

**Сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, "Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн дүрэм"-ийн 8 дугаар зүйлийн 8.11.20 дахь заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн ээлжит бус хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. Худалдаа, хөгжлийн банкны холбогдох этгээд болох Монголын Ипотекийн Корпораци ОССК ХХК-тай энэхүү тогтоолын Хавсралтад заасан нөхцөлтэй "Зээлийн эрх нээх гэрээ" байгуулахыг зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээ, хэлцэл болон холбогдох бусад баримт бичигт Худалдаа, хөгжлийн банкийг төлөөлөн гарын үсэг зурах, холбогдох этгээдэд дамжуулан итгэмжлэл олгох болон шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д олгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын алба (Н.Нямсүрэн)-нд даалгасугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ**
**ЗӨВЛӨЛИЙН ДАРГА** **РАНДОЛФ КОППА**

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК
9023082016 2023534 АТА10859
TRADE AND DEVELOPMENT BANK JSC

Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 08 тоот тогтоолын хавсралт

**Гэрээний нөхцөл**

| **Гэрээний нэр** | **Зээлийн эрхийн дүн** | **Зээлийн хүү** | **Зээлийн эрхийн хугацаа** |
|---|---|---|---|
| Зээлийн эрх нээх гэрээ | 10,000,000,000.00 (арван тэрбум) төгрөг | Зээлийн эрхийн үндсэн болон хэтэрсэн хугацааны хүү: жилийн 18.00 хувь<br><br>Зээлийн эрхийн ашиглагдаагүй дүнд тооцох шимтгэл: жилийн 2.0 хувь<br>(шимтгэлийг зээлийн данс нээгдсэн өдрөөс эхний ашиглалт хүртэл тооцохгүй бөгөөд ашиглаж эхэлсэн өдрөөс эхлэн шугамын дуусах хугацаа хүртэл шимтгэл тооцно). | 24 сар |